

**“Алтан хүрдэн мянган хигээст” хэмээх монгол түүхэн сурвалжийн зохиогчийн тухай**

Л.Халиун  
МУИС. МХСС

Уг зохиолыг Зуу-Үдийн чуулганы Жарууд баруун гарын хошууны Үлэмж билигт<sup>1</sup> эрдэнэ гүүш Чойжамц хэмээн олонд алдаршсан Дарма гүүш бээр Тэнгэр тэтгэгчийн дөтгөөр он (1739)-д эл түүхийн тулгар бичгийг зохиожээ. Тэрбээр 1741-1749 онд “Данжуур”-ыг монголчлох бэлтгэл болгож нэр томъёог жигдлэн журамласан “Мэргэд гараахын орон” нэрт толь бичгийг найруулж<sup>2</sup>, “Данжуур”-ын монгол орчуулгыг хянах ажилд оролцсон байна. Дарма гүүш “Гангын урсгал”-ыг зохиосон Гомбожав гүнтэй ойр дотно харьцаатай байсан бололтой. Түүнчлэн, Төвдийн эмнэлэгийн ухааны зохиол “Лхантав”(*ලෘංජාතාව*) буюу нэмэлт аргыг Тэнгэр тэтгэгчийн 12-р он(1747)-д орчуулжээ. Энэ ном модон бараар нэлээд тархсан бөгөөд Ш.Чоймаа багшид нэг хувь буй. Уг номын нэр нь *བྱନ୍ଦୁ བྱନ୍ଦୁ ང བྱନ୍ଦୁ ལ བྷୁ ང ལ བྷୁ* буюу “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увидасын эрдмийн үндэсний нэмэлгийн арга эвэршлийн халуун энэлгийг арилгагч хэтбүү ра цаг бусын үхэлийн салмыг(цалмыг) огтлогч илдэн хэмээх” болно. Дарма гүүш уг орчуулгын төгсгөлийн үгэнд, “...Намо гүрү. Амьтны итгэл Шакъягийн хаан Биндерья гэрэлтийн бие болон арван тоотон ухааны дотроос эмлэх(эмнэх) ухааныг номлохуйд ачит хоёр арш болон хувилаад үзэгч номлогчийн дүрээр үзүүлсэн адилтгашгүй итгэл нугуудад бие, хэл, сэтгэлийн бишрэлээр мөргөму. Эрхин итгэл тэр бус бас судар дандрын дотроос номлосон нугуудын таалалыг эрхин Наганзуна мэргэд баатар тэргүүтэн таалалыг тайлсан олон шаштирыг зохиогч хийгээд энэхүү Дөрвөн үндсэн болгон алдаршуулсан оюу дээвэрт хийгээд хүний нэр тэргүүтэн эртний бодгост, энхрэн хүсэхүй сэтгэлээр сөгдөн мөргөму, эндуурэлийн түйтгэрийг арилган соёрх. Тэдгээр ухааныг номлосон нугуудын дотроос эрхилэн эрдмийн үндсэнд гүнээ алдаршсан “Увидасын нэмэлгэ(нэмэлт) арга цаг бусын үхэлийн сэлмийг огтлогч” хэмээх үүнийг таван өнгө, дөрвөн харь улсын эзэн хүчний хүрдэн оруулагч суут бодг Чингис хааны хоёрдугаар дүү Хорчин улсыг эзэлсэн мэргэн Хасар эзний хорин тавдугаар үеийн хөвгүүн Манж улсын тэнгэр Тайсан хааны хүүхэн, улсын ариун итгэлт гүрүний(улсын) гүнжийн ач хөвгүүн сүсэг лүгээ төгөлдөр буяны хүчин лүгээ төгссөн Хорчины жүн ван Агаанбазарбо лугаа түүний тахилын орон эмч гэлэн ялгуусан Чимгийн далай-тан лугаа эрхин ямандагийн сүмийн тэргүүн Да лам Сайн саналт буянд

<sup>1</sup> Билигт гэдэг нь, төвд хэлийг онцгой сайн эзэмшсэн лам нарын дотроос билигт ламыг сонгон шалгаруулдаг. Билигт лам нь бурхан шашны ном судрыг төвд хэлнээс монгол хэлэнд орчуулахын зэрэгцээ шинээр уншлага зохиох, нэртэй лам нарын цэдиг түүхийг бичих, сүм хийд, гол гол шүтээн, бурхадын хөрөг зэргийг тайлбарлан бичих үүрэгтэй. Мөн сүм хийдийнхээ он дарааллын бичгийг бичдэг.

<sup>2</sup> “Мэргэд гараахын орон” нэрт толь бичгийн төгсгөлд уг толийг зохиоход оролцсон хүмүүсийн нэрсийг дурдсаны дотор “Жарууд ширээт Үлэмж билигт эрдэнэ гүүш Чойжамц”

*ཇ ལ ཕ ལ བྷ བ ཉ བ ལ གྷ ང ཅ ང ཅ ང ཆ ང ཇ ང ཁ ང ཇ ང ཁ* хэмээн тэмдэглэжээ.

дуршигч хамбо бээр үүнийг орчуул, олны тусад хэвийг сийлгэсүгэй хэмээсний тул дорнохи шашны садан дээд ламын зарлигаар *Үлэмж билигт ширээт гүүш хэмээх бус нэр Жарууд гэлэн Чойжамц нэрт* орчуулан үйлдвэй. Энэхүү тэжэхүй ухааны орон өгүүлэгдэх утга гүн бөгөөд би бээр тэжээх ухаанаа төгс хэмжээт сургуульд судласангүй тул утгыг онон мэдэх хаана болох. Өгүүлэгч угсийн бичиг Бээжингийн дармал судар эс арилснаар нэр үг мэдэх бэрх. Дуун ёгтын нэр үг үсэг гурван тэргүүтэнд мэргэн бусын дээр төвд хэлний эгэл үгэнд эс судалснаар ариун болгон орчуулах бэрх боловч дурдагч эх эзэд бөгөөд цөв цагийн өвчний энэлгэтийн зовлонт) олны тусыг сэтгэсэн ба нөхцөгч(нөхөрлөгч) хоёр лам бээр шамдан хичээх их болоод энэ зарлиг үгээс давах бэрх тул эрхин дээд лозава нарын сайн номлолгод шүтэж, эртний угсийн аяаг дагаад үүнийг орчуулбай. Алгасангуйн зарц Дарма би бээр дуулах ухааны оронд өгүүлэхүйн арслан мэргэдийн манлай Лхүндүвжамцын таалалаар родра хэмээх төмөр бичин жилийн шошаг сарын арван тавнаа Шакъягийн арслан Ариун идээт хааны хөвгүүн болон төрснөөс нааш хоёр мянга долоон зуун найман жил болсон арван гутгаарын анх сайтар болсон гал туулай жилийн мэргэшир сарын шинийн тэргэл дүүрсэн өдрөө *Буддын Их амгалан сайтар дэлгэрсэн тив хэмээхүйд*, орчуулан төгсгөсөн үүнээ, эс мэдсэнийг төгс хэмжээт мэргэд нүгүүд, үзмүй засан өршөө. Шил мэтийн сэтгэлээр өгүүлэгч өгүүлэгдэхүүн утгыг мэдлийн хирээр шинжлээд, тэжээгч тэжээгдэхүүний туслыг санааны хирээр санасан лугаа нэр үгэнд хэдий бүх зөвийг олсон түүгээр шалтгааны гурван хороор долоон тамир, гурван хирт үүсгэсэн үрийн гурван зүйл долоон төгөлдөр өвчнөөс тонилж, эрхин дээд бодид амраар одоод, дээр үгүй их аршийн хутгийг олох болтугай, хамгаар. Үүнийг орчуулан дурдаад хэвийг сийлэгч ван хийгээд, эрхилэн хичээгч Да лам лугаа эмч гэлэн ба үүнийг цаасанд буулгагч гэлэн Номын ухаан лугаа умзад гэцэл Гэлэгдаржаа хийгээд үүний хэвийг цааснаа бичигч гэсгүй гэлэн Цэпил лугаа гэцэл Чойнпил-тан эхлэн хичээсэн буян түүгээр, ер бурханы шашин эрдэнэ хийгээд ялангуяа хоёрдугаар ялгуусны номлохуй бүтээхүйн шашин өнөд дэлгэрэн оршоод, түүнийг баригч шашны эзэн нутгуудын өлмийн лянхуа батдаж, шашныг тулагч хаад, эзэд тэргүүтний насан буян дэлгэрэн, хамаг амьтны амар жаргалан хотол төгсөөд, эдүгээ цөв цагийн амьтны үйл явдал ширүүдсэнээр, үүнээ найман гишүүнээр хураагдсан өвчний далайгаас тийн тонилж, эрхэт Очир дара чандмань эрдэнийн дээд хутгийг амар хялбар олох болтугай. Сарва мангалаам.” хэмээн дэлгэрэнгүй бичсэн байна.

Өвөр Монголын профессор Б.Жигмэд гуай бичихдээ, анагаах ухааны зохиолуудаас төвд хэлнээс монгол хэлнээ орчуулагдан модон бараар хэвлэгдэж тархсан нь “Ман аг Лхантав” болно. “Үлэмж билигт ширээт гүүш Жарууд гэлэн хэмээн алдаршсан Чойжамц арван гуравдугаар равжуны улаагчин туулай жил(1747)-д *Буддын Их амгалан сайтар дэлгэрсэн тив хэмээхэд* орчуулан төгсгөж, Бээжин хотод хэвлэсэн модон барын монгол хэвлэл болно. “Лхантав”-ыг монголчилсон энэхүү Чойжамцыг бас монголоор Оюундалай гэж санскрит хэлээр Дарма гэж орчуулан тэмдэглэсэн байдаг. Энэ бол тэр үеийн Зуу-Үдийн чуулганы Жарууд баруун гарын хошууны хүн болно. Жарууд баруун гарын хошууг тэр үед бас “Адиша бэйлийн хошуу” гэдэг байжээ.

ХХ зууны үеийн Германы монголч эрдэмтэн В. Хайссиг түүний зохиолдоо, Чойжамцыг “Жарууд гэлэн Чойжамцыг бас Дарма гүүш гэдэг” гэжээ. Чойжамц бас “Мэргэд гараахын орон” хэмээх төвд монгол дохионы бичгийг зохиоход гол хүний нэг нь болж оролцсон бөгөөд “Алтан хүрдэн мянган хигээст” хэмээх зохиолыг 1739 онд

зохиосон байна. “Данжуур”-ын доторх зарим зохиолыг монголчлон орчуулахад бас оролцжээ”<sup>1</sup> гэж тодорхой дурдсан байна.

Эрдэмтэн Б.Болдсайхан<sup>2</sup> “XVIII зуунд Жарууд гэлэн Чойжамц(Дарма гүүш) 1747 онд “Нэмэлт арга” буюу “Лхантав”-ыг орчуулсан” хэмээн дурджээ.

Эрдэмтэн Чойжи Дарма гүүшийг ““Онол наминчлахуйн тайлбар-гэмийн харанхуйг арилгагч наран зул”(Тэнгэр тэтгэгчийн 23-р он буюу 1758 он) хэмээх анагаах ухаан хийгээд уншлагын тайлбар судрыг төвд хэлнээс монголчилсон” гэж үзсэн байна.

Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” хэмээх зохиолын нэгэн хувилбар эх нь *Хөх хотын дэвтэр* юм. Раашпунцаг “Болор эрих”-ээ бичихдээ гол баримжаа болгосон сурвалжийн нэг нь Дарма гүүшийн эл түүх бөгөөд эш татах зэргээр олонтоо нэр дурдсан байдаг. Энэ талаар “Болор эрих”-д дурдахдаа, “Раашпунцаг би бээр гүүш Дарма-гийн бичсэн “Алтан хүрдэн мянган хигээст” бичгийг байцаан үзвээс....Тэнгэрийн тэтгэсний дөрөвдүгээр онд гүүш Дарма-гийн бичсэн түүхийг гучин хоёрдугаар он(1767)-д дараалан хуулж бичээд, долоон бүлгийн тоог эвдсэн хийгээд сүүлд зохиолын тэмдэгүүдийн төдийхнийг оруулбаас бүрүн үүгээр би сайн яруу алдрыг олмуй за хэмээн дотроо мүшээж баясан өөрийн нэрээ тавьжээ. Үүнийг үзвээс өөрийн чихээ бөглөж, хонх хулгуусан мэт... ”<sup>3</sup> гэнээс үзэхэд “Алтан хүрдэн мянган хигээст” нь гар бичмэл хуулбар эхээр нэлээн тархаж байжээ. Үүнээс үзвэл, Раашпунцагт “Алтан хүрдэн мянган хигээст”-ийн нэгэн эхээс гадна алдаа мадагтай хуулбарлаж, зохиогчийн нэрийг сольсон бас нэгэн эх байсан бололтой. Эрдэмтэн Чойжи уг сурвалжийн хувилбар эхүүдийг харгуулан нягтлах явцдаа Хөх хотын хувилбар эхийн эхний дөрвөн дэвтэр нь “Сумадишила” хэмээх хүний 1767 онд Долон нуурын Хөх сүмд хуулан бичсэн мадагтай дэвтэр, хойнох хоёр дэвтэр нь Тэнгэр тэтгэсний гучин тавдугаар он (1770)-оос хойхно өөр нэгэн хүний хуулан бичсэн эх бололтой хэмээн тодруулаад, Раашпунцагийн нэр заалгүй орхисон тэр хүн нь Сумадишила мөн гэж нотолжээ. Монгол “Данжуур”-ын мэдээгээр Бикчу Сумадишила хэмээх нь санскрит үг бөгөөд даруй bhikchu sumadi sila, төвдөөр ឃុំសុំវុំសុំសុំនុំសុំ bolj, монголчилбол “Сайн оюут сахилын гэлэн” буюу Лувсанцүлтим хэмээх гэлэнгийн нэрийн санскрит орчуулга болно. Эртний Энэтхэгийн хэл шинжлэлч Панины бичсэн “Санскрит хэлний зүй”-г монголчилсон хүн юм.

Дарма гүүшийг “Данжуур”-ын зарим хэсгийг орчуулж байсан гэсэн мэдээ байгаа бөгөөд энэ тухай академич Д.Цэрэнсодном гуай бүтээлдээ тэмдэглэжээ.<sup>4</sup>

Данжуурын уг мэдээг модон барын монгол данжуураас нягтлан үзвэл,

“belge ügei inü gün narin böged  
dooradu nujud ber ülü medekü-yin  
tula. tegüber ele begetü-yin jang  
üile-yi. ende gem ügegüy-e nomlabai.  
byiruwazan-a-yin bütügel-ün arγ-a-yin jang üile-yi

<sup>1</sup> B. Jigmed, mongol anayaqu uqayan-u teüke bolun surbulji bičig-ün sinjilege, liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 2004, 150-152 дугаар тал

<sup>2</sup> Б.Болдсайхан, “Буддын сургаал ба Шинжлэх ухаан”, УБ, 2003. х-379.

<sup>3</sup> Раашпунцаг, Болор эрих, 197-198 дугаар тал

<sup>4</sup> Д.Цэрэнсодном. “ Монгол бурхан шашны уран зохиол”, ШУА. ХЗХ.УБ, 1997. 39-40 дугаар тал

ilayuysan-u gerel bayisi-yin jokiyaysan  
 tegüsbe.  
 töbed-ün kelen-eče mongyol-un  
 kelen-dür jarud-un güüsi  
 ayay-a tekimlig čoyijamsu  
 orčiγuluγad, basa ber arıγun  
 sayurin süme-yin terigün blam-a  
 urad-un güüsi yondan tan  
 nayiraγulju jasaγad sudur-tur  
 orsiγulbai. manggalam<sup>5</sup> хэмээн 66 дугаар ботийн төгсгөлийн үгэнд нэлээд  
 тодорхой тэмдэглэжээ.

Эрдэмтэн Чойжи<sup>6</sup> Дарма гүүшийг “XVIII зууны үед алдаршсан зургаан их түүхчдийн нэг бол Дарма гүүш ба гурван их лам эрдэмтдийн ахмад нь бөгөөд бусад түүхчдийн адил Монголын Алтан ургийн “тод түүх”-ийг бүтээе хэмээж Дайчин улсын үед уг зохиолоо бичжээ” хэмээн үнэлснийг бас дурдах хэрэгтэй.

Эцэст нь дүгнэн хэлбэл, Дарма гүүшийн мэндэлсэн он болон таалал төгссөн цаг үе нь үл мэдэгдэж байгаа боловч XVII-XVIII зууны үед амьдарч байсан нэрт зохиолч, орчуулагч, түүхч төдийгүй олон талын эрдэм мэдлэгтэй хүн гэдэг нь нэгэнт түүний зохиол бүтээлүүдээс тодорхой харагдаж байна.

## Ном зүй

- Бүрнээ Д. Энхтөр Д. *Төвд-Монгол толь бичиг*, Улаанбаатар, 2001.
- Дамдинсүрэн Ц. *Монгол уран зохиолын дээж зуун билэг оришвой*, Улаанбаатар, 1959.
- Дарма гүүш *Алтан хүрдэн мянган хигээст*, Монгол бичгээс хөрвүүлж тайлбар хийсэн
- Т.Жамъянсүрэн, Л.Халиун нар. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, боть 15, МУИС, МСТ, МХСС, Эх бичиг-Алтай судлалын тэнхим, УБ, 2006.
- Сүхбаатар О. *Монгол хэлний харь угийн толь*, Улаанбаатар, 1999.
- Сэцэнцогт. *Монгол угсийн язгуурын толь*, Жанжаа, 1988.
- Халиун Л. Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” (1739) хэмээх монгол түүхэн сурвалжийн эх бичгийн судалгаа, /магистрын ажил/, УБ., 2007.
- Цэвэл Я. *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966.
- Чойжи. *Монголын бурхан шашины түүх*, (Их монгол улсын үе 1206-1271), ΘМАХХ, 1998.
- Чоймаа Ш. нар. *Буддын шашин, соёлын тайлбар толь*, I, II, Улаанбаатар, 2000.
- Чоймаа Ш. “*Монголын нууц товчоо*”, *Лувсанданзаны “Алтан товч” эхийн харьцуулсан судалгаа*, Улаанбаатар, 2002.

## Summary

In conclusion although the date of birth and pass away of Dharma güüši are unknown it is clear that he was a great written, interpreter, historian living in 17-18<sup>th</sup> century from his creations and works.

<sup>5</sup> Монгол Данжуурын 66 дугаар боть, 466 дугаар хуудас.

<sup>6</sup> Дарма. Алтан хүрдэн мянган хигээст. Чойжи тулган харьцуулж тайлбарлав. ΘМАХХ., Хөх хот, 1987.